




**МОНГОЛ УЛС: МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САР
ТУТМЫН ТОЙМ**

2016.03

Үзүүлэлтүүд:


ДНБ 2.3% 2015 оны IV-р улирал урьдчилсан гүйцэтгэлээр	ГШХО 2-р сард -15.5 сая ам.доллар	Төсвийн тэнцэл -615.7 тэрбум төгрөг	Инфляци 1.7%	Чанаргүй зээл 965 тэрбум төгрөг	Валютын нөөц 1.1 тэрбум ам.доллар
Аж үйлдвэр, барилгын салбар 9.1%-иар тус тус өссөн нь нөлөөлөв.	Цэвэр ГШХО 2-р сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.2 сая ам.доллараар өсч, өмнөх сараас -42 сая ам.доллараар буурч -15.5 сая ам.доллар болов	Төсвийн орлого 1095.2 тэрбум төгрөг зарлага 1710.9 тэрбум болж төгрөг, тэнцэл (615.7) тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.	Өмнөх сараас 0.5 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 1.7 хувиар өслөө.	Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх сараас 8.6% буюу 76 тэрбум төгрөгөөр өсч, 965 тэрбум төгрөгт хүрэв. Нийт зээлд ээлэх чанаргүй зээл 8.2% байна.	Монголбанкны валютын нөөц өнгөрсөн оны мөн үеэс 12.1 хувь буюу 165 сая ам.доллараар буурч 1197 сая ам.доллар болов.
	Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш 2048.90 ₮		Орон сууцны үнийн индекс 1.045 Өмнөх сараас 0.9%-иар, өмнөх оны мөн үеэс 10.9%-иар тус тус буурлаа.		Монголбанкны бодлогын хүү 12%



АСЕМ-ын дээд түвшний 11 дүгээр уулзалт, АСЕМ-ийн 20 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд энэ оны гуравдугаар сарын 1-нийг АСЕМ-ийн өдөр болгон зарлаж, улс даяар тэмдэглэн өнгөрүүлэхээр шийдвэрлэв. Тус шийдвэрийг засгийн газрын хуралдаанаар хоёрдугаар сарын 29-нд баталсан байна.

Экспортод гаргадаг гол түүхий эдийн үнэ, хэмжээ

Манай улсын экспортын гол бүтээгдэхүүний сар тутмын экспортын хэмжээ болон дундаж үнийг графикаар, хүснэгтээр оны эцсийн байдлаар үзүүлээ.



Сүүлийн 3 жилийн хугацаанд МУ-ын экспортын түүхий эд (Мянган ам.доллар, тонн)

Голлох бүтээгдэхүүн	2013 он		2014 он		2015 он	
	Тонн	Ам.доллар	Тонн	Ам.доллар	Тонн	Ам.доллар
Чулуун нүүрс	18,194	1,116,153	19,482	850,615	14,426	555,027
Төмрийн хүдэр	6725	654,333	8,338	448,378	6,325	227,200
Зэсийн баяжмал	650	948,951	1,378	2,575,636	1,379	2,280,135
Нийт	25,569	2,719,437	29,198	3,874,629	22,130	3,062,362

Эх сурвалж: Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газар


Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

ДНБ ДНБ 2015 оны 4-р улирлын байдлаар (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 15.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 461.8 тэрбум төгрөгөөр өсч эдийн засгийн өсөлт 2.3% болов. Үүнд аж үйлдвэр, барилгын салбар 9.1%-иар тус тус өссөн нь нөлөөлөв. Эдийн засгийн өсөлт ийнхүү удаашралтай байгаа нь ХАА, үйлчилгээний салбарын хөрөнгө оруулалт бага байгаатай холбоотой.



Төсөв

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ гуравдугаар сард 1095.2 тэрбум төгрөг, зарлага, эргэж төлөгдөх зээлийн хэмжээ 1710.9 тэрбум төгрөг, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл (615.7) тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеийнхээс 471.1 тэрбум төгрөгөөр өсөхөд орлого 10.8 хувиар буурч, зарлага 24.6 хувиар нэмэгдсэн нь нөлөөлжээ.



Валютын ханш

Гуравдугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 62.90 төгрөг буюу 3.2 хувь, өмнөх сартай харьцуулахад 16.4 төгрөг буюу 0.8 хувиар нэмэгдэж 2048.90 төгрөгөөр сулрав.



Инфляци

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2016 оны 3-р сард өмнөх сараас 0.5%, өмнөх оны мөн үеэс 1.7% өссөн байна. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2016 оны 3 дугаар сард өмнөх оны эцсийнхнээс 1.7 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 8.1 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн



* Урьдчилсан гүйцэтгэл; Эх сурвалж УБСЕГ, Монголбанк

Гадаад валютын нөөц


Гадаад валютын улсын албан нөөц 2016 оны 2-р сарын байдлаар 1197 сая ам.доллар болов. Энэ нь өмнөх сараас 9.5 хувь буюу 126 сая ам.доллар, өнгөрсөн оны мөн үеэс 12.1 хувь буюу 165 сая ам.доллараар тус тус буурсан байна.



* Эх сурвалж Монголбанк

MSE-20 индекс


2016 оны гуравдугаар сард 15.7 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 0.5 сая ш үнэт цаас арилжигдсан нь өмнөх сарынхаас гүйлгээ 3.7 тэрбум төгрөг буюу 19.1 хувь, өмнөх оны мөн үеийнхээс гүйлгээ 35.5 тэрбум төгрөг буюу 69.3 хувиар буурч, арилжигдсан үнэт цаас өмнөх сарынхаас 0.4 сая ш буюу 45.3 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 0.6 сая ш буюу 53.9 хувиар буурчээ. ТОП-20 дундаж индекс 2016 оны 3 дугаар сард 11191.2 нэгж болж, өмнөх сарынхаас 603 нэгж, өмнөх оны мөн үеийнхээс 2325 нэгжээр буурчээ.



*Монголын хөрөнгийн бирж


Мөнгө

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2016 оны гуравдугаар сарын эцэст 10 их наяд төгрөг болж, өмнөх сараас 98.77 тэрбум төгрөг буюу 0.9%-иар өсч, өмнөх оны мөн үеэс 210 тэрбум төгрөг буюу 2.1%-иар өсөв. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө тайлант сард 658.5 тэрбум төгрөг болж, өмнөх сарынхаас 3 тэрбум төгрөг буюу 0.4%-иар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 44.2 тэрбум төгрөг буюу 6.2%-иар буурчээ.



Хадгаламж

Нийт хадгаламж 2016 оны 3-р сард 7.5 их наяд төгрөг болж өмнөх сараас 134.8 тэрбум төгрөг буюу 1.8 хувиар өссөн байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 202 тэрбум төгрөг буюу 2.7 хувиар өссөн үзүүлэлт юм. Ийнхүү, өмнөх сараас нийт хадгаламж өсөхөд төгрөгийн хадгаламж 1.8 хувиар буюу 97 тэрбум төгрөг, валютын хадгаламж 1.8 хувиар буюу 37.9 тэрбум төгрөгөөр өсөв.



Зээл

ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2016 оны гуравдугаар сарын байдлаар 11.8 их наяд төгрөг болж, өмнөх сараас 200 тэрбум төгрөг буюу 1.7%-иар өсч, өмнөх оны мөн үеэс 444 тэрбум төгрөг буюу 3.6 %-иар буурав. Харин чанаргүй зээлийн хэмжээ 965 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 8.6% (76 тэрбум төгрөг)-иар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 37.3% (262 тэрбум төгрөг)-иар өссөн байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 8.2%-ийг эзэлж байна.



Ипотекийн зээл

2016 оны 2-р сарын байдлаар нийт ипотекийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 0.7 хувь (24.7 тэрбум төгрөг), өмнөх оны мөн үеэс 17.3 хувь (510 тэрбум төгрөг)-өөр нэмэгдэж нийт 3.4 их наяд төгрөгт хүрэв. Хоёрдугаар сард нийт 447 зээлдэгчид 1.9 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгож, нийт зээлдэгчдийн тоо 77673-д хүрэв. 2016 оны 2 дугаар сарын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдлийн 98.7 хувь нь төгрөгийн зээл, 1.3 хувь нь гадаад валютын зээл байгаа ба нийт ипотекийн зээлд эзлэх чанаргүй зээл 0.8 хувийг эзэлж байна.




* Эх сурвалж Монголбанк

Гадаад худалдаа

Гадаад худалдаа

2016 оны гуравдугаар сард худалдааны нийт бараа эргэлт 1558 сая ам.доллар, үүнээс экспорт 959 сая ам.доллар, импорт 599 сая ам.долларт хүрч гадаад худалдааны тэнцэл 360 сая ам.долларын ашигтай гарлаа. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 221.4 сая ам.доллар буюу 12.4 хувь, үүний дотор экспортын хэмжээ 118.7 сая ам.доллар буюу 11 хувиар, импортын хэмжээ 102.6 сая ам.доллар буюу 14.6 хувиар тус тус буурчээ. Үүнд, эрдэс бүтээгдэхүүний экспорт 137.7 сая ам.долл, машин тоног төхөөрөмжийнх 10.9 сая ам.долл, хүнсний бэлэн бүтээгдэхүүнийх 8.2 сая ам.долл, үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн зүйлийнх 3.7 сая ам.долл, ургамлын гаралтай бүтээгдэхүүнийх 1.3 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлөв.



* Эх сурвалж ҮБСЕГ, Монголбанк

Гадаадын шууд хөрөнгө оруулалт

Гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 2016 оны хоёрдугаар сард -15.5 сая ам.долларын сөрөг дүнтэй гарлаа. Энэ нь өмнөх оны мөн үеэс 16.2 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм. Өмнөх сартай харьцуулахад -42 сая ам.доллараар буурсан үзүүлэлттэй байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалтад МУ-аас гадаад руу гаргасан хөрөнгө оруулалт -0.6 сая ам.доллар байсан бол Монгол Улсад 11.8 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгджээ.




* Эх сурвалж Монголбанк


Монгол Улсын гадаад өр

Гадаад өр

2015 оны дөрөвдүгээр улиралд Засгийн газрын нийт гадаад өр 3.6 тэрбум ам.доллар, Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 21.6 тэрбум ам.доллар болсон байна. Энэ нь өмнөх улирлаас ЗГ-ын өр 3 хувь (107.3 сая ам.доллар), Улсын нийт гадаад өр 0.5 хувь (120 сая ам.доллар)-аар тус тус буурсан байна. Тайлант улиралд нийт Улсын гадаад өрийн 17 хувийг засгийн газрын өр, 9 хувийг Төв банкны өр, 9 хувийг хадгаламжийн байгууллагуудын өр, 16 хувийг бусад салбаруудын өр, 49 хувийг компани хоорондын зээллэгийн өр тус тус эзэлж байна. Төв банкны нийт өрийн 96 хувийг богино хугацаат, 4 хувийг урт хугацаат өглөг эзэлж байна.



МУ-ЫН НИЙТ ГАДААД ӨРИЙН БҮТЭЦ ХУВИАР



* Эх сурвалж Монголбанк

Засгийн газрын гадаад өрийн 2015-2017 оны төсөөлөл

Үзүүлэлтүүд	2014.09.3 Гүйцэтгэл	Тэрбум төгрөг		
		2015 он	2016 он	2017 он
ЗГ-ын гадаад зээлийн өр	3,911.50	4,089.20	4,299.10	4,169.30
ЗГ-ын гадаад үнэт цаасны өр	2,760.80	2,625.00	2,550.00	2,490.00
Засгийн газрын баталгаа	2,305.50	2,515.80	2,439.20	1,312.50
Засгийн газрын гадаад өрийн дүн	8,977.80	9,230.00	9,288.30	7,971.80

* Эх сурвалж Сангийн яамнаас гаргадаг тайлан мэдээ

Гадаад өр, зээлжих зэрэглэл

Зээлжих зэрэглэл	S&P		Fitch	
	Монгол Улс	Тогтвортой	В	Сөрөг
Огноо	2015.11.05		2013.12.13	

Standard & Poor's Монгол Улсын зээлжих зэрэглэлийг 11-р сард "B+" зэрэглэлээс "B" зэрэглэлд болгож бууруулав. Монгол Улсын зээлжих зэрэглэл буурсан шалтгааныг тэд гадаадын хөрөнгө оруулалт буурсан, гадаад валютын урсгал багассан, өрийн ачаалал үүсч болох эрсдэлт нөхцөл үүссэнтэй холбон тайлбарлаж байна.

Moody's :

Moody's агентлаг нь зээлжих зэрэглэлийг тогтооходоо C ангиллаас AAA хүртэл 21 ангилалд зэрэглэл тогтоодог ба мөн хэтийн төлөвийг сөрөг, тогтвортой гэж үнэлдэг.

Огноо	Зээлжих зэрэглэл	Хэтийн төлөв
2005 оны 10 дугаар сар 4-нд	B1	Тогтвортой
2009 оны 6 дугаар сарын 10-нд	B1	Сөрөг
2009 оны 10 дугаар сарын 30-нд	B1	Тогтвортой
2014 оны 5 дугаар сарын 26-нд	B1	Сөрөг
2014 оны 7 дугаар сарын 17-нд	B2	Сөрөг

Moody's 2014 оны 7-р сард Монгол Улсын зээлжих зэрэглэлийг бууруулсан.

Moody's агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг B1 -ээс B2 сөрөг болгож бууруулсан. Үүний шалтгааныг Монгол Улсын гадаад өрийн хэмжээ сүүлийн жилүүдэд огцом өссөн, инфляци өндөр байгаа нь чанаргүй зээлийн хэмжээг нэмэгдүүлж, банкны системийг бүхэлд нь эрсдэлд оруулах магадлалтай гэж үзжээ. Түүнчлэн гадаад валютын нөөц буурч байгааг эрсдэлд тооцжээ.

Үүний зэрэгцээ Moody's засгийн газрын үнэт цаас гаргагч ба бондын үнэлгээг B1, засгийн газрын дунд хугацаат өрийн бичгийн үнэлгээг B1, мөн богино хугацааны үнэлгээг "not prime" буюу төлбөрийн чадвар сул зэрэглэлд хэвээр үлдээсэн.

03.07

Азийн хөгжлийн банк, Зээлийн батлан даалтын сан хооронд байгуулах “Зээлийн батлан даалтын системийг дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байр бий болгох” төслийн гэрээнд өнөөдөр гарын үсэг зурлаа.

03.22

Казах түмний наурызын баяр өргөн дэлгэр болов. Наурыз бол шинэ жилийн эх нь бөгөөд хаврын өдөр, шөнө тэнцсэн өдөртэй давхцдагаараа онцлогтой. Наурыз гэдэг нь иран хэлний “ноу-шинэ, руз-өдөр” гэдэг үгээс бүрдэж оны эхний өдрийг илэрхийлдэг. Казах хэлэнд наурыз гэдэг нь жилийн эхэнд тэмдэглэгдэх өргөн олон түмний баяр, байгаль орчин, ан амьтан нойрноос сэрж амь ордог өдөр шөнө тэнцдэг үе юм.

03.25

Засгийн газрын 82-р тогтоолын дагуу энэ сарын 25-26 шилжих шөнө цагийн тоолол нэг цагаар урагшилж, зуны цагийн тоололд шилжлээ. Засгийн газраас жил бүрийн 3 дугаар сарын сүүлчин долоо хоногийн баасан гарагаас бямба гарагт шилжих шөнө 02 цагаас эхлэн 9 дүгээр сарын сүүлчийн долоо хоногийн бямба гарагт шилжих шөнийн 00 цаг хүртэлх хугацаанд Монгол Улсын нутаг дэвсгэрт цагийн тооллыг нэг цагаар урагшлуулж ажил, үйлчилгээ эхлэх цагийн хуваарийг мөрдөж байхаар тогтоосон билээ.

Тойм

“Ипотекийн зээл, санхүүжилтийн ерөнхий журам” батлагдав.

Тэтгэвэрийн нөөц сангийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай хэлэлцэж, “Ипотекийн зээл, санхүүжилтийн ерөнхий журам”-ыг засгийн газрын ээлжит бус хуралдаанаар батлав. Ирээдүйн тэтгэвэрийн нөөц сангийн тухай хууль батлагдсантай холбогдуулан тус сангийн 2016 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулж Засгийн газарт танилцуулан УИХ-ын хаврын чуулганаар хэлэлцүүлэх, сангийн 2016 оны төсвийг батлах хүртэлх хугацаанд хууль болон журмыг хэрэгжүүлэхтэй холбоотой бэлтгэл ажлыг хангаж, Ирээдүйн тэтгэвэрийн нөөц сангийн тухай хуульд заасны дагуу Монголбанктай гэрээ байгуулах, ипотекийн зээл олгох үйл ажиллагааг холбогдох байгууллагатай хамтран үргэлжлүүлэн хэвийн, тасралтгүйгээр зохион байгуулахаар болж байна. Мөн Улаанбаатар хотын шинэ болон гэр хорооллын дахин төлөвлөлтийн бүс, алслагдсан дүүрэг, 21 аймгийн нутаг дэвсгэрт хөтөлбөрийн хүрээнд орон сууц худалдан авах ипотекийн зээлийн хүүг цаашид үе шаттайгаар бууруулах арга хэмжээ авч ажиллахаар болсон байна.